

Далан хоёрдугаар зүйл

Таслан шийдвэрлэх тогтоолын  
тухай мэдэглэх

1. Өнгөрсөн жилд Хэлэлцэн Тохирогч нөгөө Этгээдийн харьяатын талаар өөшйн шуухээс гаргаж хучин төгөлдөр болсон тогтоолын тухай мэдээг жил бүрийн эхэнд Хэлэлцэн Тохирогч хоёр Этгээд харилцан солилцож байхаар уурэг авав.

2. Хэлэлцэн Тохирогч нэг Этгээд Хэлэлцэн Тохирогч нөгөө Этгээдийн хусэлтээр тэдний хаобьяатын талаар өөрийн шуухээс таслан шийдвэрлэсэн бусад бух тогтоолын / хучин төгөлдөр болоогуй ч орно/. мэдээг явуулка. Шаардлагатай уед хусэлт явуулж байгаа Хэлэлцэн Тохирогч Этгээдийн харьяат биш иргэний тухай ч мэдээллийг өгч болно.

3. Энэ зүйлийн I, 2 дахь ангид заасан даалгавар, мэдээг дипломат шугамаар явуулж байка,

2. Шилжтүлэн өгөх

Далан гуравдугаар зүйл

Шилжуулэн өгөх үүрэг

Өөрийн нутаг дэвсгэрт байгаа иргэнийг эруугийн гэмт хэрэгт баривчлах буюу тууний таслан шийдвэрлэсэн тогтоодыг гуйцэтгуулэх зорилгоор Хэлэлцэн Тохирогч хоёр Этгээд аль нэгнийхээ шаардлагаар энэхуу Гэрээнд заасан нөхцлийк дагуу харилцан бие биедээ шилжуулэн өгч байх уурэг авав,

Далан дөрөвдүгээр зүйл

Шилжуулэн өгөх шаардлагатай гэмт  
хэрэг

I. Хэлэлцэн Тохирогч хоёр Этгээдийн хууль тогтоонжоор зөвхөн нэг жилээс дээш хугацаагаар хоригдох ял бухий эруугийн